

## Чингис хааны тахилгын соёлын бурхны шашны нөлөөг шинжлэх нь

Сурнаа

(Өвөр Монголын Их Сургууль)

**Abstract:** Genghis Khan worship ceremony is a memorial tradition that preserves the customs of Mongolian sacrifice culture. In the long history, the ceremony conserves the characteristics of Shamanism by following mainly the rituals and rules of Shamanist tradition. However, the impact of the foreign religion - Buddhism on Genghis Sacrifice ceremony should not be neglected. This paper mainly discusses about the impact of Buddhism on this ceremony.

**Keywords:** Genghis Khan Worship Ceremony, Buddhism, Influence

**Товч утга:** Чингис хааны тахилга бол монголчуудын эртний тахилга тайлгын заншил ёсыг өвлөн хадгалж ирсэн уламжлалт тахилгын соёл юм. Уг тахилга нь уламжлагдан дамжигдахдаа монголын уугуул шашин бөө мөргөлийн соёлын ёс заншлыг хадгалсаар ирсэн байна. Энэхүү тайлга ёслолыг гүйцэтгэх явцдаа бөө мөргөлийн шашны зан үйлийг мөрдөн гүйцэтгэж ирсэн бөгөөд ирмэл шашин нь бурхны шашны зан соёлын нөлөөг зохих хэмжээнд хүртсэн юм. Өгүүлэлд Чингис хааны тахилгын бурхны шашны нөлөөг аль талаар хэрхэн хүртсэнийг задлан шинжлэв.

**Түлхүүр үгс:** Чингис хааны тахилга, Бурхны шашин, нөлөө, үйлдэл

### 1. Бурхны шашин Монголд дэлгэрсэн

Бөө мөргөлийн шашин нь монголчуудын хувьд уугуул шашин нь болох юм. Яг иймэрхүү уугуул шашин болох учраас монгол хүн бүр энэ ертөнцөд ирмэгц өөрийн эрхгүй энэхүү уугуул шашны ёс заншилд хүлээслэгдэн шүтлэгтэн болдог учиртай. Гэтэл бөө мөргөл нь бусад шашин шиг олон зүйлийн ёс журам байдаггүй. Шашин нь тухайн шашны номлолын их хөлгөн судар, сүм хийд гэх мэт тухайн шашны суурин газар (сахил санваар, хорио цээр), шашныг уламжлагч (бурхны шашны лам нар) хэмээх гурван зүйлийг бүрдүүлэх хэрэгтэй. Бөө мөргөлийн шашин дээрх системийн адил номлолын ёс, шашны хөдөлгөөн гэх тогтсон газар орон байдаггүй. Бусад шашин шиг суралцах, боловсрохоор дамжин шүтлэг бишрэл олдог биш, харин хүмүүсийн хэвшсэн зан дадалд түшиглэнэ. Хүмүүсийн ухамсар дотор тэр нь ямар нэгэн танилтын бүрэлдэхүүн биш, хүмүүсийн үзэл ухамсар дотор ямарваа нэгэн бодитой орон байрыг эзэлж чаддаггүй. Тэр нь зөвхөн хүний бүхий л үзэл ухамсарт тархан оршиж чаддаг. Өөрөөр хэлбэл, бөө мөргөлийн шашныг шүтдэг хүмүүсийн үзэл ухамсар дотор бусад шашин шүтлэгийг гадуурчлах ухамсар бага байдаг. Иймээс бөө мөргөлийн сүсэгтэн бусад шашныг амархан хүлээн авч чаддаг юм.

“Хэрэв төвдийн уламжлалт соёлд бон шашин болон түүний хожим оруулсан бурхны шашин нь шашны чухал бүрэлдэхүүн бол монгол соёлд хамгийн гол нөлөөлсөн нь бурхны шашин болно”<sup>1</sup>. Хубилай хаан бурхны шашнаар бөө мөргөлийн төрийн шашны байр суурийг орлуулав. XIII зуунд монголын хаад, ноёд бурхны шашинтай анх ойртох үеэс зөвхөн улс төрийн зорилготой байжээ. Монголын хаад ноёдын дотор хамгийн анх Төвдийн Бурхны шашинтай ойртсон хүн бол Өгөдэй хааны хүү Гүдэн (闊端) юм. 1247 онд Гүдэн Лянжөүд Төвдийн бурхны шашны Сажагийн бүлгийн багш Сажа бандид Гунгаажалсантай уулзав. Тэд Төвд орон бууж өгөх нөхцөлийг хэлэлцэв. 1251 онд Хубилайн цэрэг Люфань шань ууланд буудаллах үеэс Лянжөүд хүн томилон Сажа бандид Гунгаажалсаныг залсан байна. Тэр үед Сажа бандид Гунгаажалсан нас өндөр, бие өвчтэй тул ач Пагваг томилон явуулав. Хубилай 17 настай Пагватай уулзан түүний бурхны шашны тухайлбал Төвд орны түүхийн баялаг мэдлэгтэйг ихэд магтан сайшаав. Хубилай хожим нь хаан ор сууснаар Пагваг улсын багшаар өргөмжлөв. Тэр цагт бурхны шашин Юань улсын ноёрхолд үнэнчээр үйлчлэн, Юань улсын хаан суурийн бат бэх, улсын нэгдлийн бүрэн бүтнийг хамгаалах, Төвдийн орны тогтуун байдалд чухал нөлөө үзүүлсэн юм. Юань улс умард уруу нүүж, монголын төрийн доройтлыг дагалдан, бурхны шашин болон монгол төрийн хоорондох харьцаа тасрав. Монгол төрийн доройтол болон бурхны шашны бууралтаас болж бөө мөргөл дахин монголчуудын гол шүтлэг болов. Бурхны шашин Монгол оронд хоёр дахь удаагаа орж ирсэн нь XVI зууны үе юм. Бурхны шашны Гэлэгвагийн сургаал монгол оронд уламжлан дэлгэрсэн шалтгааныг гурван талаар хураангуйлж болно.

**Нэг.** Гэлэгвагийн бүлэгтэн бол Төвдийн ламын шашны дотор хамгийн сүүлд хөгжин цэцэглэсэн их шашны бүлэгтэн юм. Түүний цэцэглэлтийн үе нь XV зууны дунд үе бөгөөд түүнийг үүсгэгч нь Зонхав (1357-1419) юм. Тэр Төвдийн энэ бүлгийн доройтолд задлал хийж ёс журмыг эрхэмлэхээр гол онол болгон шашинд өөрчлөлт хийсэн байна. Энэхүү өөрчлөлт нь сүсэгтэн түмний тухайлбал дээд давхаргын ноёрхогч анги, засаг төрийн тусламжийг олж Гэлэгвагийн бүлэг болон хөгжив. Зонхав болон түүний шавь нар шар малгай зүүж, шар хувцас өмсдөгөөс энэхүү бүлгийг шар малгайтны бүлэгтэн буюу шарын бүлэгтэн гэдэг. XV зууны 90-ээд оны эхээр гэлэгвагийн бүлэгтнийг дэмжиж байсан засаг төрийн дотоодын самуурал, доройтлоос болж тэд бусад эсэргүү этгээдийн дарангуйлалтай учрав. Энэхүү байдалд гэлэгвагийн бүлэгтэн өөр хүчирхэг хүчнийг түшиглэх буюу холбогдох нь цаашид оршин тогтноход тулгамдсан шаардлага болов. XVI зууны дундаж болон сүүлчээр Төвдтэй хил хязгаар нийлж байсан Хөхнуур орон бол Монголын баруун гурван түмний хөдөлгөөн гэж байсан газар байжээ. Ийм байдалд гэлэгвагийн бүлэгтнийхэнд Монголыг түших санаа төрж эхлэв.

<sup>1</sup> Өлзийбаяр, “Монгол-Төвдийн соёлын харилцааны судалгаа”, Хятадын Төвд судлалын хэвлэлийн хороо, 2003 он, 3дугаар сар, 14-р тал.

**Хоёр.** Монголын талд XIII зууны 50-аад онд Түмэд түмний Алтан хан нэгэнт баруун гурван түмний бодит эрхийг гартаа оруулсан байв. Тэр хэдэн арван жилийн хугацаа зарцуулан, өмнө зүгт Цагаан хэрэм, зүүн зүгт Цахар, баруун зүгт Хөхнуур, хойд зүгт Халх хүртэлх газрыг эрхшээлдээ оруулан өөрийн ноёрхлыг тогтоов. Хөхнуур оронд Монгол, Төвд, Хятад, Уйгар, Турк, Ёгор, Дуншян зэрэг аймаг угсаа байсан боловч Алтан хаан болоод баруун гурван түмний ноёдын анхаарлыг татсан нь Төвд хийгээд тэдний бурхны шашин байв. Алтан ханы хувьд шашны үзэл суртлаар дамжуулан Гансу, Хөхнуур, Төвд зэрэг орны хооронд бий болсон зөрчилдөөнт харилцааг зохицуулах нь Хөхнуураас ухран гаргахыг шаардах Мин улсын дарамтыг эсэргүүцэхэд ашигтай байв.

**Гурав.** Бөө мөргөлийн “хааны эрхийг тэнгэрээс олгосон” хэмээх үзэл нь Алтан хаан эрхээ улам бататгахад үзэл санааны хязгаарлалт болж байв. Даян хан их ор суусны дараа “бөө мөргөлийн шашны тэнгэрийн заяаны онол” болон Чингис хааны алтан урагтны хойчсын нягт харьцаа тухайлбал шашны онолоор жинхэнэ алтан урагтны удам угсааг тайлбарласан байдаг. Иймээс онолын талаар эртний бөө мөргөлийн шашны “тэнгэрийн заяаны онол”-ыг феодлын засгийн дүрэмд хэрэглэсэн нь үзэл санааны завшаан болсон байв. Энэ нь алтан урагтны хааны эрхээ өнө үүрд батлахын төлөө юм. Даян хаан нас барсны сүүлээр түүний ахмад ач хүү Бодь-Алаг хаан орыг залгамжлав. Үүнээс хойш Чингис хааны алтан ургийн хойчсын Даян хааны ахмад ач хүү хаан орыг залгамжлах тогтолцоо болж бүрэлджээ”<sup>2</sup>. 1571 онд гэлэгвагийн бүлэгтний Ашин (阿兴) лам болон Алтан хаан уулзалт хийв. Тэр үеэс Ашин лам түүхээр иш татан, зорилготойгоор Алтан хааныг Хубилай хааны хувилгаан хэмээн үзэж мөн Алтан хааныг гэлэгвагийн бүлэгтний тэргүүн Содномжамцтай харилцахыг ятгав. 1574 онд Алтан хаан хүн томилон Содномжамцын гэгээнд бараалхуулав. Содномжамц бээр Алтан хааны элчид өөрийн бие болон Алтан хаан нь Пагва болон Хубилай хааны хувилгаан мөн гэснийг албан ёсоор тунхаглав.

Монголын бөө мөргөл нь дайн дажин, булаан дээрэмдэх байдлыг бууруулж, хүмүүсийн оюун санаанд түшиг тулгуур болж сэтгэлийн гүний зовлон, эмгэнэлийг арилган өгч чадахгүй байв. Энэ нь мөн бурхны шашин сэргэх нэг зүйлийн шалтгаан болж байв. Дээр дурдсан нөхцөл байдлууд нь бурхны шашин Монгол оронд дэлгэрэх урьдач нөхцөлийг хангаж өгөв. Эрдэмтэн Б.Я.Владимирцовын хэлсэнчлэн “Хэрэв нийгмийн өөрийн биед нь шинэ үзэл санааг хүлээн авах тохиромжтой хөрс үгүй бол нэгэн засаг төр нь нэг зүйлийн сүсэг бишрэлийг тийм түргэн дэлгэрүүлж яасан ч чадахгүй”<sup>3</sup> байдаг.

Бурхны шашин монгол оронд уламжлагдан хагас зууны хугацаа бололгүйгээр монголын олонх аймгууд түүнийг шүтэх болж монгол газар сүм хийд, лам нар олшров. Бурхны шашин Монгол оронд уламжлан тархсан нь монголын

<sup>2</sup> “Монгол үндэстний нэвтэрхий түүх”, Өвөр монголын нийгмийн шинжлэх ухааны хүрээлэнгийн түүхийн хүрээлэн, Үндэсний хэвлэлийн хороо, 1991 он, 589-590-р тал

<sup>3</sup> Б.Я.Владимирцов: “Монголчуудын нийгмийн байгууллын түүх”, Үндэсний хэвлэлийн хороо, 1980 он, 495-р тал

нийгмийн улс төр, аж ахуй, цэрэг дайн, соёл зэрэг салбарт их өөрчлөлтийг бий болгов. Чингис хааны тахилга ч мөн бурхны шашны энэхүү их нөлөөллөөс зайлан гарч чадсангүй.

## 2. Чингис хааны тахилга дахь бурхны шашны элемент

Чингис хааны тахилга бурхны шашны нөлөөг хүртсэнийг “Арван буянт номын цагаан түүх”-д “Хаврын тэргүүн хувь сарын арван таван Бурхан багш Магада рид хувилгааныг үзүүлнэ. Шуламсыг даран хаврын дунд хоёр сарын арван таван Очирт суурин илтэд туулсан бурхан болжээ. Түүнд нэгэн буян үйлдвээс түг түмэн хувь болох тул хаврын буяныг тэр хоёр сар үйлдмүй”<sup>4</sup> гэж тэмдэглэснээс мэдэж болно. Юань улсын үед бурхны шашин монголын дээд давхаргын хүрээнд нэлээд дэлгэрч байсан тул Чингис хааны тахилгын дөрвөн цагийн горимд бурхны шашны зан заншил их нэмэгджээ. Ингэхээр Чингис хааны тахилгыг бөө мөргөл болон бурхны шашны нөлөөг хүртсэн хосолсон ёслол байж хэмээн ойлгож болдог.

“Арван буянт номын цагаан түүх”-д бас “Түүний хойно Күшаний Жад Монголын газар Очирваанийн хувилгаан Тэмүүжин нэрт хан хөвүүн төрж, эрсийн эзэн хэмээх арван хоёр их хаан нугуудыг дураараа болгон, хамаг замбуутивийг эрхэндээ оруулж урьдасын байгуулсан хоёр ёсыг тэгшид эрхлээд хурлын эзэн суут Чингис хааны нэр нь тэнгэрийн дуурьсан замбуутив ертөнцөд түгээмэл сонстжээ”<sup>5</sup> гэх тэмдэглэл буй. Энэ тэмдэглэлээс үзвэл Чингис хааныг бурхны шашны бодисунгийн нэг Очирваанийн хувилгаан болгосноор хүмүүст Чингисийн онгоныг шүтэх ба бурхны шашны бурхан номыг шүтэх явдал нь хоорондоо нэгдэлтэй гэх ёсыг ухуулж буйг ойлгож болно. Пагва ламын үеэс бурхны сахиус, хаад ноёдын санскрит нэр цолыг монгол хаадад өгдөг заншил бий болжээ. Жишээлбэл, Хувилай Сэцэн хаанд өргөсөн “Чакраварди” гэх эртний энэтхэгийн хааны цол эдүгээ болтол түүх шастирт тэмдэглэгдэн үлджээ. Сая дурдсан Чингис хааныг Очирваанийн хувилгаан болгосон явдал бол Пагва ламтай холбогдох юм. Чингис хааны тахилгын тэнгэрийн хэлний арван хоёр дуунд Чингис хааныг “их буянт бодисун, егүүтгэлгүй жаргатугай энх нут”<sup>6</sup> гэж дуулдаг. Ер нь тэгээд Пагва, Далай, Банчен зэрэг бурхны шашны багшаас өөр хүн Чингис хаанд ийм шашны нэр цол нэхэмжлэн өргөх ёс байж болшгүй байдаг. Энэ мэт шашны томчуудаас Чингис хаанд нэхэмжлэн өргөсөн нэр цол монголчуудын дунд нэлээн хожуу үе болтол нөлөө ихтэй байсныг бид “Эзэн богдын сэржим”-ээс мэдэж болно. “Эзэн богдын сэржим” эхлэнгүүт “Төгс цогт Очирваанийн хувилгаан, дэлхий дахиныг тэтгэхийн тэнгэр, тэнгэрлэг

<sup>4</sup> Лю Жинсун эмхэтгэн тайлбарлав: “Арван буянт номын цагаан түүх”, Өвөр монголын ардын хэвлэлийн хороо, 2000 он, 89, 76-р тал

<sup>5</sup> Лю Жинсун эмхэтгэн тайлбарлав: “Арван буянт номын цагаан түүх”, Өвөр монголын ардын хэвлэлийн хороо, 2000 он, 89, 76-р тал.

<sup>6</sup> “Алтан ордны тайлга”-ын “Алтан ордны голомтын их өчиг”, “Богд Чингис эзний даллага оршив” зэргийг лавлана.

эзэн Чингис хэмээх тэдгээрийн хатдыг залмуй<sup>7</sup>” гэсэн байв. Чингис хааны өчиг даатгал, сан, тахилга тэргүүтэнд байн байн “Очирваань баатар бодисун болон хувилсан, Онон мөрний Дэлүүн болдогт төрсөн, хуу төгс цогт Очирваанийн тодорхой хувилгаан”<sup>8</sup> гэж гардаг. Үүнээс үзвэл “Чингис хааныг Очирваанийн хувилгаан болгож, Чингис хааныг тахивал Очирваань шүтсэн лүгээ ижил”<sup>9</sup> байдаг.

Энэ нь XVII зууны монгол хаадыг Энэтхэг, Төвдийн хаадтай гарал нэгтэй хэмээн үзэх үзлийн тусгал мөн. Үүний тухай “Хаадын үндэсний хураангуй Алтан товч”-д анх дурдсаныг “Эрдэнийн товч”-д хамгийн нарийн дэлгэрэнгүй тооцжээ. Тухайлбал, “Чухал хэрэглэгч төгс утгат шастир”, “Улаан дэвтэр” ба “Маш тодорхой ухагдахуун хэмээх судар”-уудад бурхны шашны үүсэл хөгжил, дэлгэрсэн түүхийг Энэтхэг, Төвд, Монголын хаадын үйл ажиллагаатай холбож хэлэх агуулгын системийг бий болгож өгчээ<sup>10</sup>. “Арван буянт номын цагаан түүх”-д “Эрт Энэтхэгийн газар Махасамади хааны байгуулж Шагжамуни бурхны шинэтгэн засаж явуулсан хойно Төвдийн гурван эх Чакравардийн хаан даган орж, хоцролгүй, төгөлдөр, тэгшид явуулснаар бас монголын газар суут Чингис хаан өвөг минь сайтар явуулж, улс иргэн оргоныг зассан ажгуу”<sup>11</sup> хэмээн Хубилай хааны хэлсэн үгийг тэмдэглэсэн байдаг.

Шарын шашин монгол орон (Ордос)-д дэлгэрсэн нь Чингис хааны тахилгад шууд нөлөөлөв. Манж Чингийн үед их эзэн хороо, сүм хийд байгуулжээ. Түүнчлэн уламжлалт Чингис хааны тайлга, тахилгад ч шарын шашны сүсэг бишрэл буй болж үе улиран Чингис хааны найман цагаан гэрийг сахисан дархадын хойчсын нэг бүлэг нь лам болов. Чингис хааны цомцог ордонд өдөр бүр сан тавин, давхар цомцгийн гадна ордонд хэнгэрэг цан, бүрээ зэрэг лам нарын ном уншихад хэрэглэдэг эдлэлийг тавьдаг болов. Чингис хааны тахилгын эвхмэлийг эмхэтгэн тэмдэглэсэн “Чингис хааны найман цагаан орд”-д таван зуун өргөө дархадын хүн ам тоон бүртгэлд ламын тоог дурдсан байдаг. Үүнээс үзэхэд дархадын лам нь таван зуун өргөөнөөс салбарлан гарч ирснийг гэрчилж байж. Мөн таван зуун өргөө дархадын ерөнхий тооны нэг хэсэг байж таарна.

“Таван зуун өргөө дархадыг Энх-Амгалангийн гучин тавдугаар (1696) онд гаргасан нь тодхон байна. Таван зуун өргөө айлын зонхилох хэсэг нь Ордосын хошуудаас ирсэн байна. Шилийн голын чуулганы Сөнөдөөс Гэлүгэн баатрын удам угсааны хорин найман өргөө айл ирснийг Төр гэрэлтийн үеийн бичиг хард тэмдэглэж буй. Дархадын хорч нарын хэсгийн айлууд нь арван чуулганы

<sup>7</sup> “Алтан ордны тайлга”-ын “Алтан ордны голомтын их өчиг”, “Богд Чингис эзний даллага оршив” зэргийг лавлана.

<sup>8</sup> “Алтан ордны тайлга”-ын “Алтан ордны голомтын их өчиг”, “Богд Чингис эзний даллага оршив” зэргийг лавлана.

<sup>9</sup> Н.Хурц, “Ихэс лам нар Чингисийн тайлгыг шашиндаа авч орох гэсэн нь”, Өвөр монголын нийгмийн шинжлэх ухаан, 1997 оны 4 дүгээр хугацаа.

<sup>10</sup> Батбагана, “Монгол үндэстний гүн ухааны үзэл санааны түүхийн судлал”, Өвөр монголын ардын хэвлэлийн хороо, 1993 он, 241-242-р тал.

<sup>11</sup> Лю Жинсун эмхэтгэн тайлбарлав, “Арван буянт номын цагаан түүх”, Өвөр монголын ардын хэвлэлийн хороо, 2000 он, 89, 76-р тал

тэндээс ирсэн айлууд байжээ”<sup>12</sup> хэмээн таван зуун өргөө дархадыг гаргасан цаг хийгээд бүрэлдэхүүн тухайлбал, тэдний ирсэн газар нутгийг тодорхойлсон байдаг. Дархадын зохион байгуулалт туйлын будилаантай юм.

“Монгол тахилга” хэмээх номд “Тэнгэрийн тэтгэсний гучин хоёрдугаар (1767) оноос эхлэн дархадын нутагт сүм байгуулж, Сайшаалт ерөөлтийн үед сүм барихыг улам сайшааснаас дархадын нутаг дээр урьд хожид шугуйн сүм зэрэг найман сүмийг байгуулсан”<sup>13</sup> гэх тэмдэглэл буй. Энэ нь ламын тоог нэмэгдүүлсэн мөртөө Чингис хааны найман цагаан гэрийн тахилгын зан үйлд бурхны шашны зан үйл бий болохыг ахиулж, угийн дан ганц тэнгэр газрын тахилга, дээдсийн тахилгын өнгө будгаа алдсан бурхны шашны соёл нэвчсэн тайлга болсон байна.

Сайшаалт ерөөлтийн хорин гуравдугаар (1768) оны өвлийн сүүл сарын шинийн долоонд чуулганы тэргүүн Содномравжаагэндэнээс Чингис хааны найман цагаан ордныг сахисан дархадын газарт сүм байгуулсан тухай их зургаад мэдүүлсэн бичигт “Найман цагаан ордон сахисан Билгүүндалай, зайсан Батжаргал та бүхэн таван зуун өргөө ард нарын хамт мэдүүлэхийн дотор өлзий бататгахын тул манай нутгийн Баянбулаг нэртэй газар тавин, жян сүм байгуулж, үүнд дөчин банди нараар ном уншуулахыг гуйх нь ... Жа фүда-ийн лам тавих дөчин бандид гэрээс магад гарсан тэмдэг бичиг олгох ажаамуу<sup>14</sup>” гэсэн тэмдэглэл буй. Сайшаалт ерөөлтийн хорин таван (1770) оны зуны сүүлч сарын хорин нэгний чуулганы тэргүүн Содномравжаагэндэний Чингис хааны найман цагаан ордны харьяат билиг эрхэм сүмийн банди нарын нэрийг тэмдэглэн баталгаажуулах тэргүүн лам Лүнрүвбалданд тушаасан бичигт “Үүрд хуврагийн жилийн мөрийг цаг үргэлжид захиж ёсоор явуулахын учир мөнхүү билиг эрхэм сүмд зарлигаар соёрхож нэрийг хайрлаад, эхэнд сууж номын сургууль гэх ба шавдан гүрэм уншиж суусан дөчин хуврагт гэрээс магад гарсан бичгийг их зургаанаас тушаан хүрч ирснийг тус бүр олгож явуулав<sup>15</sup>” гэж тэмдэглэж байв. Мөн тэмдэглэлд энэ дөчин бандийн нэр, зүс байдлыг жагсаан тэмдэглэсэн байдаг. Энэ хоёр данс бол “Чингис хааны найман цагаан орд”-д тэмдэглэсэн хамгийн анхны сүм хийдийн лам нарын данс болно. Энэ нь Чингис хааны тахилгын бурхан шашны нөлөөг авч судлахад баримт болж чадна. “Чингис хааны найман цагаан орд”-д лам нартай холбогдсон данс 5 хувь байна.

### 3. “Эзэн сан” болон “Эзэн сангийн раш”

Чингис хааны тахилгад “Эзэн сан” ба “Эзэн сангийн раш”-ийг дууддаг. Эдгээр сангийн ерөөл нь бурхны шашны нөлөөг хүртсэн нь илхэн байна. “Эзэн сан” ба “Эзэн сангийн раш” гэх хоёр шүлэг бол Чин улсын үеийн

<sup>12</sup> Сайнжаргал найруулав, “Монгол тахилга”, Үндэстний хэвлэлийн хороо, 2001 он, 138-р тал.

<sup>13</sup> Сайнжаргал найруулав, “Монгол тахилга”, Үндэстний хэвлэлийн хороо, 2001 он, 137-р тал.

<sup>14</sup> “Чингис хааны найман цагаан орд”, “Чингис хааны найман цагаан орд”-ын эмхэтгэн найруулах дугуйлан эмхэтгэн найруулав, Өвөр монголын соёлын хэвлэлийн хороо, 1998 он, 71-72-р тал.

<sup>15</sup> “Чингис хааны найман цагаан орд”, “Чингис хааны найман цагаан орд”-ны эмхэтгэн найруулах дугуйлан эмхэтгэн найруулав, Өвөр монголын соёлын хэвлэлийн хороо, 1998 он, 73-р тал.



Урадын баруун гүнгийн хошууны Мэргэн хийдийн гуравдугаар дүрийн гэгээн Лувсандамбийжалсан (1717-1766) бурхны магтаалыг дуурайн зохиосон Чингис хааны магтаал юм. Энэхүү магтаал шүлгийг одоо Чингис хааны их бага аль ч тайлгын урьд сан тавин “Эзэн сан” хэмээн уншлага уншдаг. Ингэхдээ энэхүү “Эзэн сан” хэмээх магтаал шүлгийг тайлга эхлэх бүр уншихаас гадна өдөр бүрийн өглөө, үдийн хойно цагаан гэрт хоёр удаа заавал сан тавьж “Эзэн сан” уншдаг. “Энэ нь шарын шашин монгол оронд хөгжин дэлгэрэхийн хамт гарч ирсэн заншил”<sup>16</sup> бөгөөд энэ заншил нь “Ордост өргөн дэлгэрсэн юм. Айл өрх өглөө эрт хийморийн сангийн сүр дээр арц хүж шатаан сан тавьж эрэгтэй хүмүүс нь сөгдөн сууж “Эзэн сан”, “Сүлдийн сан”-г уншин Чингис хаанд чин үнэнч байгаагаа илтгэн бүх гэрийн амгалан жаргалан байхыг даатгадаг”<sup>17</sup> юм.

Чингис хааны тахилгад даатгах “Эзэн сан” нь:

“Ума хум, ума хум, ума хум

Зэ! Лам ядам гурван чухаг дээдээр эхлэн

...

Найман бадмын үзэсгэлэн дэвсгэрийн дээр

Найраг төгс сахиулсан их Цагаан увш

...

Зуун амт бүрдсэн идээний дээж

Сүүний амт бүрдсэн рашааны шимээр

Суут богд Чингис хаан нөхөдлээрийг тахимуй.

Бадрангуй галын цогц маш сайтар бадар

Бадрангуйн зул бүхэн зулсаар тахимуй

Зандан хөхөл арц хүж түлсний үнэдээр тахимуй

Сангийн эх үлэмжит үнэдээр тахимуй

...

Тэнгэрийн хаан зарлигаар эдийг барин тэтгэгч

Төгс хүчин үйлдэгч түргэн ридийн хүчээр

Тэрс номт хаадын дайныг талхан довцог болгоод

Таван өнгө дөрвөн харийн улсаа товчлон

Найман түмэн дөрвөн мянган хаадын эрхэм болсон

Номын хүрдэн хаан мэт их агуу хүчнээр

Тэрс номт дайсан тотгор хорлогчийг чадагч

Төгс хүчин сахиулсан таныг магтан мөргөмүй

...

Бурхан багшийн шашин лугаа харшлагч дайсан дор”<sup>18</sup> гэх мэтээр тэр ёсоороо богд эзэнд тахил өргөсөн бурхны шашны тахилын шүлэг болох юм.

<sup>16</sup> Сайнжаргал, Шаралтай цуглуулан эмхэтгэв, “Алтан ордны тайлга”, Үндэсний хэвлэлийн хороо, 1983 он, 30-р тал.

<sup>17</sup> Сайнжаргал, Шаралтай цуглуулан эмхэтгэв, “Алтан ордны тайлга”, Үндэсний хэвлэлийн хороо, 1983 он, 30-34-р тал.

<sup>18</sup> Сайнжаргал, Шаралтай цуглуулан эмхэтгэв, “Алтан ордны тайлга”, Үндэсний хэвлэлийн хороо, 1983 он, 30-34-р тал.

Энэ нь Чингис хааны алдар гавьяаг магтан дуулахын зэрэгцээ богд эзний гэгээн сахиуснаас хойчистоо эдлэл малыг арвитгах, урт насан, амар жаргал эрхшээлийг бататгах, онц үйлс бүтээхийг захъя зэрэг олон сайн сайхан аврал соёрхол хүртэхийг хүсэн гуйдаг байна. Хамгийн сүүлд нь зохилдохын үйлсийг маш сайтар бүтээх, үргэлжид жаргалангийн өлзий хутаг орших болтугай хэмээн бэлгэ дэмбэрэлтэй сайн үгээр зөгнөн төгсдөг.

“Эзэн сангийн раш” –д :

“Есөн хүслийг зуны нүүр мэтээр арвиж  
Гэмүүд үгүй овог бүр мөрд үл тасар  
Өдөр шөнийн богд ламын номуудаар уншсан  
Хотол төгс чуулсан өлзий хутаг орш  
Хичээл ба шимтүүлэхүй хэрэглэхүйг нэмэхүл  
Чандмань эрдэнээр галбарбаасан модоор  
Амьтны эгээрлийг сайтар ханган үйлтгэ  
Сэтгэлчлэн бүтэхүйн өлзий хутаг орш  
Өдөр бүхэн амгалан шөнө жаргалан  
Өдөр дунд бүгдээр амгалан болсон  
Эрхэм гурван эрдэнэсийн өлзий хутаг орш”<sup>19</sup> гэж мэндчилэн өгүүлдэг.

2010 оны Цагаан сүргийн тайлгын “Эзэн сангийн раш”-ийг тэмдэглэснийг сийрүүлбэл:

“Есөн зүйлийн хүсэлд чинь зуны нуур шиг өгсүгэй!  
Ариун цагаавар овог угсаатан нэг бүрийн ул мөр өнөд орштугай!  
Өдөр шөнө минь ламын номоор дуталтгүй байтугай  
Олны хурсан хишиг өнөд оршигтун  
Мануус олон хэрсүү борогжуун болтугай  
Алт мөнгө эд эрдэнэс бүх хүчээр амьтан бүхний хүслийг хангатугай  
Санасан санаа сэтгэлчлэн бүтдэг хувь заяатад хүртээмүй  
Өдөр намжуун шөнө амаржуун болтугай  
Өдөр бас энх амгалан байтугай  
Өдөр бүр өнөд амгалан байтугай

Гурван зүйлийн эд эрдэнэсийн хишиг өнөд орших тун<sup>20</sup> гэжээ. Энд тэмдэглэсэн болон одоо тайлгад дуудагдаж байгаа “Эзэн сангийн раш” үсэг бичгийн талаар бага зэргийн зөрүүтэй боловч шүлгийн үндсэн санаа бараг ижилхэн байдаг. “Эзэн сангийн раш”-ийг нягтлан үзвэл, есөн хүсэлт, өдөр шөнө ламын ном хэмээх бурхны шашны ёсны өнгө будаг ив илхэн харагддаг.

Монгол бөө мөргөлийн ёсонд гал онгосгож, утаагаар ариутгахыг их эрхэмлэн гүйцэтгэдэг. Монголчууд галыг барцдыг дарах тухайлбал, мууг арилгах ер бусын хүчтэй гэж сэтгэн түүнийг маш хүндэтгэн үздэг. Ямар нэгэн юм бузар буртаг болбол галаар ариулдаг. Энэ тухай эртний гадаадын жуулчид ба судлаачдын бүтээлүүдэд олон талаар тодорхой дурдсан байна. Жишээлбэл, монголчууд

<sup>19</sup> Сайнжаргал найруулав: “Монгол тахилга”, Үндэстний хэвлэлийн хороо, 2001 он, 138-р тал.

<sup>20</sup> 2010 оны 5 сарын 4-ний Цагаан сүргийн тайлгаас тэмдэглэв.



эртнээс “Юм бүхэн цөм галд ариутгагддаг”<sup>21</sup> ба “Эрт цагт монголчууд хүн үхэхээр гал голомтоо ариутгаж галдаа сүү, архи цацаж, их гал түлээд бүх эд хогшлоо ариутгаж үхсэн хүнийг оршуулаад ирсэн хүн ба уналгыг хоёр галын хоорондуур явуулж оруулдаг”<sup>22</sup>. Энэхүү ёс нь галаар ариутгахыг өгүүлэн мөн одоогийн Цагаан сүргийн тайлгад сан тавих ёстой нэлээд ойролцоо зан үйлийн ажиллагаа юм.

Галаар ариулахыг эрхэмлэх зан үйлийн үзэгдлүүд нь үнэндээ монгол бөө мөргөлийн зан үйлийн уламжлалын залгамжлал болно. Хожим нь бурхны шашны нэвчилтийг дагалдан монгол бөө мөргөлийн тахилгын зан үйл нь ихэд өөрчлөгдөж харилцан уялдан “сан” гэх үг монгол бөө мөргөлийн тахилгын зан үйлд шууд хэрэглэгдэх болсон буюу зарим нутагт тахилгын үйлд арц, хүж, утлага мэтийн бурхны шашны ариутгалын тусгай эдүүд нь зарим нөхцөлд монголчуудын угийн галын ариутгалыг орлосон байна. Профессор Ц. Хишигтогтох “Сан тавих ёслол бол бөөгийн шашин, бурхны шашны аль алинд байдаг юм. Одоо надад олдож байгаа бөөгийн шашны олонх сангийн шүлгүүд нь бөө удганы эртний утлагын ёс ба сүүлчийн үеийн уламжлагдаж орж ирсэн бурхны шашны сан тавьдаг ёс хоёр нийлэн уялдсан байдалтай болоод байна”<sup>23</sup> гэв. Тэрээр сангийн шүлгийг бөө мөргөл ба бурхны шашны аль нэгтэй холбогдох тухай нотолсон байна.

Монгол бөө мөргөлийн шүлэг угаасаа сангийн шүлэгтэй байв. Гэвч Чингис хааны тахилга дахь сангийн шүлэг ба сан тавих ёслол нь хожмын бурхны шашны нөлөөг ихээхэн гүнзгий агуулсан нь үнэн юм. Чингис хааны их, бага аль ч тахилгын өмнө сан тавьж бас “Эзэн сан” хэмээсэн уншлага уншиж байна. Энэхүү “Эзэн сан”-г тайлга эхлэх бүр уншихаас гадна өдөр бүрийн өглөө, үдийн хойно “Эзэн сан”-г шүтээн, ордон хоёрт заавал тавьж “Эзэн сан” уншдаг байна. Чингис хааны тахилга хэдийгээр уугуул шашин бөө мөргөлийн тахилгын зан заншилд суурилагдан уламжлагдан тахигдаж ирсэн боловч бурхны шашны зарим ёс журмыг шингээн авч хэрэглэх болсон нь үнэн юм.

### Даллагын сум

Чингис хаан болон Бөртэ хатны цомцог орд “Алтан орд”-д даллагын сумаас гадна даллагын хөнөг байдаг. Даллагын хөнөг нь элдэв эрдэнэс ба үр тарианы зүйлийг цуглуулан нийлүүлж дүүртэл хийн, дээд тал нь өргөн, доод тал нь нарийн, нэг тохой өндөр, босоо дөрвөлжин модон суулга мөн. Гадуур нь алт мөнгөөр урлаж чимэглэн, найман тахил сийлж хуарлажээ. Буян хишиг хурахын зөгнөл болгосноос даллагын хөнөг гэдэг. Энд бурхны шашны найман тахил буй.

<sup>21</sup> Ч.Далай, “Монголын бөө мөргөлийн товч түүх”, Төвийн үндэсний их сургуулийн номын сангийн хадгаламж, 65

<sup>22</sup> Гэрэлцогт орчуулав, “План Харпен, Уильям Рубрунг Монголд жуулчилсан тэмдэглэл”, Өвөр монголын сурган хүмүүжлийн хэвлэлийн хороо, 1983 он, 152-р тал.

<sup>23</sup> Ч.Хишигтогтох, “Монголын эртний утга зохиолын судлал”, Өвөр монголын ардын хэвлэлийн хороо, 1998 он, 28-р тал.

Монголчууд даллагын сумыг хишгийн сум гэдэг. Анх эртний даллагын сум нь тэнгэр газар ба гал тахихад зориулж хишиг буян хурайлах зорилготой байжээ. Хожим нь агуулгын талаар цөөн бус хувиралт гарсан боловч мөн уулийн үзэл ухамсраа хадгалсаар байна.

Даллага авах нь хишиг буяныг хурайлж байгаа бэлгэтэй явдал болохоор тусгай даллагаас гадна өөр олон зүйлийн ёслол дээр даллагыг дагалдуулан явуулдаг. Цагаан сүргийн тайлгын “Алтан ордны тайлга”-д үдшийн даллагын ёслол байдаг.

Даллага нь үйлдвэрлэлийн арга маягийн хувьсахыг дагалдан хишгийн төрөл болон даллагын хэрэгсэл нь өөрчлөгдсөн бөгөөд шашны амьдралын хувирлыг дагалдан ёслолын дэс дараа болон ёслолын шинж чанар нь ч ихээр хувирчээ. Ялангуяа Энэтхэг, Төвдийн бурхны шашин шимтэн дэлгэрэхийг дагалдан монгол даллагын ёс Төвдийн бурхны шашны ёс заншлыг ихээр шингээн авч ил тодорхой бурхны шашны шинж онцлогтой болжээ. Жишээлбэл, Цагаан сүргийн тайлгын даллага авахад хэрэглэх даллагын сумны бүтэц нь ийм байна. Даллагын сум бол арван гурван үетэй, хулсаар иш хийж сумны үзүүрийг доош хандуулан даллагын хөнөгийн амуу тариа, эрдэнэсийн дунд хатгасан байна. Хулсан ишний дээд хэсэгт гялалзсан мөнгөн толь өлгөж толины дотор захаас таван өнгийн торгыг уяж өлгөөд хулсан ишийн хамгийн дээд оройд цэвэр цагаан ноосыг бомбойлгон ороосон байдаг. Энд өгүүлж байгаа даллагын сум бол бөө мөргөлийн шашин болон бурхны шашны тайлгад хэрэглэх багажийг уялдан нийлүүлсэн нийлэг юм. Үүний бүрэлдэхүүнд бурхны шашны таван өнгийн торго, бөө мөргөлийн шашны цаашилбал Цагаан сүргийн тайлгын ёсны тэнгэр тахилгад мөнхүү хэрэглэх цэвэр цагаан ноос зэрэг буй.

“Алтан ордон” дахь даллагын сум нь богд Чингис хааны дайсныг дарахад хэрэглэсэн сумыг дурсахын тулд үйлдсэн юм. Сумны үзүүрийг амуу тариа ба эрдэнэсийн хөнөгт хатгаж байгаа нь ийм сумны тусалтын ачаар эд эрдэнэ, амуу тариа, адуу мал элбэг дэлбэг гэснийг илтгэдэг юм. “Таван өнгийн торгоор ороосон нь таван хариа төлөөлж, таван харийн амьтад таван махбод шиг харилцан зохицолдон найрамдах гэснийг илтгэж гэнэ”<sup>24</sup>. “Таван харь гэдэг нь хөх Монгол, шар Сартуул, цагаан Солонгос, хар Төвд, уран улаан Хятад”<sup>25</sup> юм.

Даллагын сумны мөнгөн толь нь аливаа бүхнийг гэгээн тунгалгаар тольдон амаржуулмуй гэсэн утгатай. Хамгийн орой дээрх ноос нь сүмбэр уулын цас цагаан оргилыг төлөөлж сүмбэр уул мэт баг бэх суурьтай, түүний дөрвөн талын дөрвөн тив (бурхны шашны домогт сүмбэр уулын дөрвөн зүгт дөрвөн тив байна гэв. Дорно зүгт Үлэмж биет тив, өмнө зүгт Замбуу тив, өрнө зүгт Үхэр эдлэгч тив, умар зүгт Муу дуут тив буй гэдэг) таван харь тогтнон амаржихыг бэлгэдэн зөгнөсөн утгатай гэнэ. Эдгээр зүйлээс гадна цомцгийн дотор алтан мөнгөн

<sup>24</sup> Сайнжаргал, Шаралтай цуглуулан эмхэтгэв, “Алтан ордны тайлга”, Үндэсний хэвлэлийн хороо, 1983 он, 18-р тал.

<sup>25</sup> Рашпунцаг зохиож, Хөхөндөр харгуулсан, “Болор эрх”, Өвөр монголын ардын хэвлэлийн хороо, 1985 он, 26-р тал.

зул, цөгц, шингэ (тайлгын өтөг шөл, бас заримдаа энэ шөлийг хутгах савыг шингэ гэнэ. Зарим газар нэг зүйлсийн саалийг шингэ гэнэ) хатгуур, сав сааль, магнаг олбог дэвсгэр, хивс түшлэг зэрэг өдий төдий үнэтэй эд хэрэгсэл байжээ. Чин улсын Тэнгэрийн тэтгэсэний үеэс шар дархадын нутагт найман хийдийг байгуулж Чингисийн цомцгийн дотор сан тавих жишээ нь лам нар гаргаснаар тэд хэрэглэдэг бумба, хуш, тодов (нэг зүйлийн сархад савлах сав), рамар (лам нарын хэрэглэдэг царын хэлбэрт хоёр талтай дундаа бариултай бяцхан хэнгэрэг хөгжим), дун хэнгэрэг, цан, ганлин бишгүүр (лам нарын хэрэглэдэг нэг зүйлийн үлээдэг хөгжим), бүрээ, мөнгөн мэнгрэ (эд эрдэнэс, тариа будааны дээжийг өргөдөг мөнгөөр хийсэн нэг зүйлийн сүсэг мөргөлийн багаж) мармай жамса (баян зул гэсэн утгатай. Бас цэцэг, зул гэвч болно) тахил зэргийн эд хэрэгслийг бас өмнө талын цомцогт тавих болжээ.

Даллагын сумны бүрэлдэц бүхэн нь бэлгэдэл утга үлэмж бөгөөд түүхэн хөгжлөө дагаж зохих хувиралттай болсон юм. Чингис хааны тайлгад хэрэглэж байсан даллагын сум нь уулын үзэл ухамсраа нэлээд хадгалж байсан ч цагаан ноосыг сүмбэр уултай холбосон нь бурхны шашинд нөлөөлөгдсөнийг харуулж байна. Энэхүү даллагын сум нь эзэн богд Чингистэй холбогдож дээдсээсээ хишиг буян хурайлж байгаа юм. Даллагын сумны орой дээрх цэвэр цагаан ноос нь Чингис хааны тахилгын дарсан заламд ороох ноостой бэлгэдэл утга нь адилгүй болжээ. Үүнд энэ нь сүмбэр уулын цаст оргилыг төлөөлж байдаг. Энд дөрвөн тив, таван харь зэрэг бурхны шашны үгс гарч байна. Бурхны шашны тахилд хэрэглэх тахилын багаж бас дурдагдаж буй. Мөн Тэнгэрийн тэтгэсэний шар дархадын нутагт найман сүмийг байгуулсныг дурдан, Чингис хааны тахилгад ламын шашны заншлын ёс хамаарагдан орсны тухай өмнө хэсэг өгүүлснийг давхар гэрчилж байна.

Ерөнхийлбөл, Чингис хааны тахилгын ёсонд уугуул шашин бөө мөргөлийн нөлөө голлох байрыг эзлэх бөгөөд бурхны шашны нөлөө нэлээд гүнзгий байдаг. Бөө мөргөлийн шашин болон бурхны шашны эсэргүүцэл, тэмцэл зүүнээс баруун тийш, өмнөөс умардыг хамран Монголын өндөрлөгт удаан хугацаанд үргэлжилсэн юм. Бөө мөргөлийн шашин болон бурхны шашны урт хугацааны харилцаа монгол соёлын хувьсалд чухал нөлөө авчирчээ. Энэхүү байдал нь зарим уламжлалт зүйл хөгжлийн явцдаа аажмаар устан үгүй болж, зарим зүйл нь уусаж дамжин хадгалагдан хоцорчээ.